

Гарчиг

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Компанийн танилцуулга.....	3
1.2 Компанийн байгаль орчны бодлого.....	3
1.3 Хүрэн Толгойн уурхайн танилцуулга.....	4
1.3.1 Байршил	4
1.3.2 Газрын засаг захиргааны харьяалал, дэд бүтэц эрчим хүч.....	4
1.4 Уурхайд ашиглагдах техник тоног төхөөрөмж.....	5
1.5 Ажиллах хүчний мэдээлэл	5
1.6 Уурхайн барилга байгууламж	6
БҮЛЭГ 2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1 Гурван тэс сумын нийгэм эдийн засаг	6
2.2 Гурвантэс сумын газар ашиглалт.....	7
2.3 Гурвантэс сумын хүн ам	7
2.4 Гурвантэс сумын эдийн засаг	7
2.5 Гурвантэс сумын мал аж ахуй	8
2.6 Боловсрол	8
БҮЛЭГ 3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1 Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
3.2 Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл	8
3.3 Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	9
3.4 Амьтан, ургамал зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	10
БҮЛЭГ 4 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	10
БҮЛЭГ 5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
5.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд.....	11
6.2 Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд.....	12
6.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
6.4 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14

6.5 Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
БҮЛЭГ 7 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 8 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 9 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨӨГӨӨ	19
БҮЛЭГ 10 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
БҮЛЭГ 11 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 12 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
<i>12.1 Хог хаягдал</i>	21
<i>12.2 Хийн хаягдал</i>	21
12.3 Химийн бодисын эрсдэлийн менежмент	21
БҮЛЭГ 13 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
13.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго, зорилтууд	24
БҮЛЭГ 14 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 15 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
БҮЛЭГ 16 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО	32

Зургийн жагсаалт

Зураг 1 Хүрэн толгой уурхайн байршил	4
--	---

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Уурхайд ашиглагдах тоног төхөөрмж	5
Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлж болзошгүй, сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	11
Хүснэгт 3 Усан орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	12
Хүснэгт 4 Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	13
Хүснэгт 5 Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	14
Хүснэгт 6 Ургамлын аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	15
Хүснэгт 7 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	16
Хүснэгт 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 9 Хог хаягдлаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ	23

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Компанийн танилцуулга

“Хүрэн Толгой Коал Майнинг” ХХК нь Монгол улсын хуулийн этгээд “МОНГОЛЫН АЛТ КОРПОРАЦИ”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Чин Хуа” группийн 50:50 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2002 оны 09-р сарын 04-нд “Чинхуа-МАК Нарийнсухайт” ХХК гэсэн оноосон нэртэй үүсгэн байгуулагдсан.

2003 оны 04-р сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 23 дахь жилдээ ажиллаж байна. Нарийн сухайтын орд газарт “Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компани”-ийн статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаад 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/02-19 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор БНХАУ-ын хуулийн этгээд “Чин Хуа” корпорацийн эзэмшлийн 50% хувьцааг шилжүүлэн авч, 100% үндэсний компани болж, компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орсон.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт орж, үндэсний компани болсонтой холбоотойгоор компанийн оноосон нэр болох “Чинхуа-МАК Нарийн сухайт” ХХК-ийг “Хүрэн Толгой Коал Майнинг” ХХК болгон өөрчилж, 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлсэн.

1.2 Компанийн байгаль орчны бодлого

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсэж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсдын нэн тэргүүний зорилт болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улсын байгаль орчны хууль, дүрэм, журам болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл билээ.

Баримтлах бодлого: “Хүрэн толгой коал майнинг” ХХК компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:


- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх

- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаарх мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

1.3 Хүрэн Толгойн уурхайн танилцуулга

1.3.1 Байршил

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага-Овоо багийн нутагт Улаанбаатар хотоос баруун урагш 849 км, Даланзадгад хотоос баруун тийш 296 км, Гурвантэс сумаас зүүн урагш 34 км, Шивээхүрэн боомтоос 56 км зайд Хүрэн толгой хэмээх газарт оршдог.



Зураг 1 Хүрэн толгой уурхайн байршил

1.3.2 Газрын засаг захиргааны харьяалал, дэд бүтэц эрчим хүч

Гурвантэс сум нь манай орны хамгийн өмнөд захын сум бөгөөд хойд ба баруун талаараа Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь, Шинэжинст сумуудтай, зүүн талаараа аймгийнхаа Сэврэй, Ноён сумуудтай, урд талаараа ӨМӨЗО-ны Эзнээ хошуутай тус тус хиллэнэ. Гурвантэс нь Монгол улсын хамгийн том газар нутагтай сум бөгөөд 2844 мян.га талбай нутаг дэвсгэртэй юм.

БНХАУ-аас өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар 35/10квт-ын ЦДАШ 108 км агаарын шугам, Шивээхүрэн боомтоос Нарийн сухайтын орд хүртэлх хатуу хучилттай 56 км авто замыг барьж Өмнөговь аймгийн алслагдсан гурван сум Гурвантэс, Ноён, Сэврэй болон Овоотын цэргийн 0166-р

анги, Шивээхүрэн боомт, “МАК” ХХК, “SGS” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Бласт” ХХК, “Шунхлай” ХХК, зэрэг байгууллагуудыг эрчим хүчний байнгын найдвартай эх үүсвэрээр хангадаг.

1.4 Уурхайд ашиглагдах техник тоног төхөөрөмж

“Хүрэн толгой” уурхай нь уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд АНУ, Беларусь, Герман, Япон, Хятад зэрэг улсуудад үйлдвэрлэгдсэн 10 төрлийн, нийт 44 ширхэг техник, тоног төхөөрөмжийг ашиглан ажиллаж байна. 2026 онд уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй жагсаалтыг (Хүснэгт 1)-д үзүүлэв.

Хүснэгт 1 Уурхайд ашиглагдах тоног төхөөрөмж

№	Зориулалт	Техник тоног төхөөрөмж	Хүчин чадал	2025 онд ашигласан техник
1	Нүүрс олборлолт	CAT 395-01	6,5m ³	1
2		ZAXIS 870	4.5m ³	2
3	Хөрс хуулалт	EX 1900	18m ³	1
4		CAT 6060	34m ³	1
5		PC2000	12m ³	1
6		RH170B	22m ³	1
7	Өрөмдлөг	Sandvik 75	251mm	2
8	Дугуйт ачигч	CAT 988	13m ³	1
9		LW1200	8m ³	1
10		856H	3.2m ³	2
11	Хөрс тээвэр	CAT 793	240тн	4
12		CAT 777	98.2тн	3
13		HD785	91тн	4
14		Тгех	90тн	6
15		Белаз 75306	220тн	8
16		Белаз 75131	130тн	2
17	Туслах техник	WD900	26m ³	1
18		GD825	13m ³	1
19		HD785 цистерн	80тн	1
20		CAT D10T	21m ³	1
Нийт				44

1.5 Ажиллах хүчний мэдээлэл

Хүрэн толгой уурхай нь нийт 164 ажилтан ажиллагсадтай. Үүнээс инженер техникийн ажилтан 16 буюу нийт ажилтны 9.75% , Орон нутгийн ажилчин нийт 94 буюу 57.31%-ийг эзэлж байна. 2026 онд уурхайн ажиллах хүчний бүтэц 196 болсон.

1.6 Уурхайн барилга байгууламж

Уурхайн ажилчдын ажиллаж амрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 120-140 хүний багтаамжтай барилга байгууламжуудыг өөрийн хүчээр барьж байгуулан ажиллаж байна. Мөн засвар үйлчилгээний төв, шатахуун түгээх станц, мод үржүүлэг, цэвэрлэх байгууламж зэргийг барьж байгуулан ажиллаж байна.



Амрах хотхон



Шатахуун түгээх станц (ШТС)



Мод үржүүлэг



Засварын талбай

БҮЛЭГ 2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Гурван тэс сумын нийгэм эдийн засаг

Гурвантэс сум нь 1954 онд анх Тост нэртэйгээр Сэврэй сумын 1-р баг, Ноён сумын 3, 4, 5 дугаар багууд нийлж Улаан толгой гэдэг газар 281 өрх, 943 хүн амтай 63.2 мянган малтайгаар байгуулагджээ. 1960 онд БНМАУ-ын ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар Гурвантэс сум гэж нэрлэгдэн, одоогийн байрлаж байгаа уртын дэнж гэх газар төвлөрсөн байна. Одоогийн байдлаар нутаг дэвсгэрийн хэмжээ 27.9 мян.кв.км байна. Хойд баруун урд талаараа Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баянговь, Баянлиг, Зүүн, Зүүн хойд талаараа өөрийн аймгийн Сэрвэй, Ноён, урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны эзний хошуутай хиллэж Говь алтайн нурууны цөлөрхөг бүсэд оршдог. Аймгийн төвөөс 320 км, Улаанбаатар хотоос 870 км алслагдан оршдог байна.

Тус сумын нутаг дэвсгэр нь Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд багтана. Гурвантэс сумын нутагт Нэмэгт, Гилбэнт, Суварга, Эрдэнэ зэрэг өндөр сүрлэг уулс, Тэгшийн гурван гол, Арван гурван даац, Бүг, Сайрдаг, Гурил, Хулангийн хөндий Шаригийн ганга зэрэг олон арван км үргэлжилсэн хөндий хоолойнуудтай, Зуун мод, Зулганай, хэрмэн цав, Наран, Наран даац, Хайлааст зэрэг горхи ус, баян бүрдүүд зэрэг хэдийд ч болов сэтгэлийг татсан байгалийн үзэсгэлэнт газруудтай. Торомхон, Нэмэгтийн баруун зүүн горхи, Салхит дуслуур, Улаан хад, Баганат зэрэг нүд ходоод, гэдэсний болон хүний бие мах бодийн эмгэгийг эмчилдэг рашаан устайгаас гадна, Хармаг, Тэмээн хөх, Жигд, Алтангагнуур, Лидэр, Хонин ба морин шарилж, Хар шаваг, улаан ба цагаан гоёо, Чихэр өвс, Нохойн хошуу, Таван салаа, Хар өвс, Зэрлэг сонгино, шувуун хөл, гоньд, Хөмүүл, таана зэрэг эмийн болон хүний хоол хүнсэнд амтлагчаар буюу энгийн байдлаар хэрэглэгддэг сайн чанарын ургамлууд ихээр ургадаг. Засаг захиргааны анхан шатны нэгж болох Гоёот /нэгдүгээр баг/, Баясах /хоёрдугаар баг/ Тост /гуравдугаар баг/ Урт /дөрөвдүгээр баг/, Бага овоо /тавдугаар баг/ гэсэн 5 багтай.

2.2 Гурвантэс сумын газар ашиглалт

Гурвантэс сум нь 2,796,727.0 га газар нутагтай бөгөөд үүнээс хөдөө аж ахуйн эдэлбэр газар 1,439,740.4 га, ойн сан бүхий газар 233738.0га, улсын тусгай хэрэгцээний газар 1,121,510.3 га-г эзэлнэ. Сумын газар нутгийн ихэнх хувийг малын бэлчээр ба тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг.

Сумын ард иргэдийн дунд газар өмчлөлийн талаар судалгаа явуулахад газар өмчилж авсан иргэд 69.8%, аваагүй иргэд 30.2%, үүнээс сумын төвд газар өмчилж авсан иргэд 98.6%, аймгийн төвд газар өмчилж авсан нь 1.4% байна. Харин газар эзэмшдэг эсэх талаар судалгаа явуулахад 56.2% нь тийм, 43.8% нь үгүй гэж хариулжээ. Сумын иргэдээс өвөлжөө хаваржааны доорх газраа албан ёсны гэрээгээр эзэмшиж байгаа байдлыг судлахад эзэмшлийн гэрчилгээтэй нь 76.8%, эзэмшлийн гэрчилгээгүй нь 23.2% байна.

2.3 Гурвантэс сумын хүн ам

Сумын хэмжээнд 2025 оны эцсээр 4,617 хүн амтай.

Гурвантэс сумын 2025 оны байдлаар хүн амын тоонд багийн эзлэх хувийг доор үзүүлэв. Тус суманд халхчууд голлон амьдардаг. Цөөн тооны буриад, дөрвөд ястан сургууль, ажил болон бусад шаардлагаар суманд гэр бүлийн хамт ирж суурьшиж байна.

2.4 Гурвантэс сумын эдийн засаг

Өрхийн орлого: Гурвантэс сумын эдийн засгийн голлох салбар нь Мал аж ахуй, уул уурхай юм. Сумын төвд төсөвт 6 байгуулга, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3 үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна холбооны салбар, банкны 4, цаг уур, шуудан холбоо, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХХК, болон Шатахуун түгээх станцууд зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд ажиллаж байна. Сумаас 55 км-т орших Дунд голын давсны уурхайгаас “ Говь гурван сайхан ” “ Асралт ” Сонгодог нөхөрлөл нь жилдээ 220 орчим тонн давс олборлож борлуулдаг байна. Мөн сумын төвөөс 25 км-т орших “Хүрэн толгой коал майнинг”, “МАК” ХХК-ний Нарийн сухайтын уурхай, “Саус гоби сэндс” ХХК, “Өсөх зоос” ХХК, Жавхлант орд зэрэг ХХК- д нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд Алтны АГМ майнинг ХХК, хайрганы Чухам жаргалан ХХК, чулууны Баатарван транс ХХК, өмнийн говийн баялаг зэрэг ХХК-д ажиллагаа явуулдаг. Сумын цэцэрлэгийн 3 байранд жилдээ 300 гаруй хүүхэд хүүхэд хүмүүжиж, 15 ортой хүн эмнэлэг, 250 суудалтай соёлын төв, номын сан болон 16 хүний бүрэлдэхүүнтэй цагдаагийн тасаг ажиллаж байна. 2005-2006 оны хичээлийн жилээс 8 жилийн дунд сургууль 11 жилийн

сургалттай сургууль болон өргөжсөн бөгөөд өдгөө хичээлийн хоёр байранд 1 мянга гаруй хүүхэд суралцаж байна.

2.5 Гурвантэс сумын мал аж ахуй

Гурвантэс сум бэлчээрийн мал аж ахуй амьжиргааны эх үүсвэр нь хэвээр байна. Бэлчээрийн мал аж ахуйн судалгаанаас авч үзэхэд тэмээ, ямааны аж ахуй өсгөх нэн зохистой бүсэд хамрагдаж байгаа боловч сүүлийн жилүүдийн байгаль-экологи, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан бэлчээрийн ургамлын гарцад өөрчлөлт орохын зэрэгцээ зарим нэг унаган ургамлуудын төрөл зүйл ч алга болжээ. Эдгээр хүчин зүйлүүдийг тогтоох шалгуур үзүүлэлтэд малын тоо толгой зүй ёсоор багтдаг. Сумын малын тоо 2023 оны жилийн эцсийн малын тооллогоор нийт 136,570 толгой мал буюу тэмээ 7,983, адуу 3,048, үхэр 530, хонь 9,338, ямаа 115,648 тус тус тоологдсон байна. 2022 оны жилийн эцсийн малын тоотой харьцуулахад нийт 37,033 толгой мал буюу 21,3 хувиар буурсан байна. Малын төрөл тус бүрээр задалбал тэмээ 582 буюу 6,7 хувиар, адуу 271 буюу 8,1 хувиар, үхэр 56 буюу 9,5 хувиар, хонь 1,950 буюу 17,2 хувиар, ямаа 34,197 буюу 22,8 хувиар тус тус буурчээ.

2.6 Боловсрол

Сумын хэмжээнд 11 жилийн тогтолцоотой 160, 320 хүүхдийн суудалтай хичээлийн 2 байртай 1 сургууль байгаа бөгөөд 1000 гаруй сурагчтай үүний 150 хүүхэд нь дотуур байранд амьдарч байна. Сургуулийн хэмжээнд нийт багш 50, ажилчид 35 байна.

БҮЛЭГ 3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосжилт, хорт хий, утаа, нүүрсний тоосонцор байж болох юм. Уурхайн байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй, говь цөлийн бүс бөгөөд ургамлын бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм. **Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим нь:** Хөрс хуулалт, хөрсний догол, мөргөцөг гаргах, мөн олборлолт хийх зэрэг ажлууд хийх явцад агаарт үүсэх их хэмжээний тоос, салхи, шуургаар дамжин тархалт ихсэн. Говийн нөхцөлд салхины хурдны давтагдал их байдаг нь ордын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрснөөс суларсан шороо хийсэж агаар бохирдуулах нь их байж болзошгүй юм. **Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ:** Уулын ажлын үед болон нүүрс тээвэрлэлтийн үед уурхайн орчимд их хэмжээний тоос, тоосонцор үүсэх бөгөөд энэ нь агаар орчинд төдийгүй уурхайн орчмын зэрлэг амьтан, мал, ургамлын бүлгэмдэл, уурхайн ажилчид болон уурхайн ойр амьдрах хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй. **Үргэлжлэх хугацаа:** Агаар мандлын бохирдол нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд маш түргэн үгүй бол маш удаан, эсвэл хүний бие махбодын тогтолцоог аажмаар удаан гэмтээх зэрэг янз бүрээр нөлөөлнө.

3.2 Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрсөн дэх органик бодисын агууламж нь 1.0%-аас бага, сул шүлтлэг, шүлтлэг чанар нь кальци, магнийн катионуудын концентрациас хамаарч хөрсний давхарга бүрд харилцан адилгүй байна. Цөлийн бор хөрс бүрэлдэх явц нь бусад төрлийн хөрснүүдээс ялгаатай байдаг. Учир нь говийн хуурай цаг уур болон ховор тохиолдох хур тунадас зэргээс шалтгаалж, хөрсний 80% нь эрдэсэжсэн байдаг. Хөрсний шинж чанар нь натрийн карбонат, бусад хэлбэрийн карбонат,

ууссан давс, шохойлогтой эсэхээс хамаарч тодорхойлогдоно. Судлаачид говийн хөрс тогтворжиход хөрсний чийгийн горим их нөлөө үзүүлсэн гэж үздэг. Түүний нөлөөгөөр хөрсний өнгөн хэсэг дээр карбонат, бикарбонат хуримтлагдаж, давс агуулсан нимгэн шаварлаг үе бий болдог. Цөлийн хөрс нь өвлийн цагт өнгөн хэсэгтээ 1-1.5 м гүнд хүртэл хөлдөнө. Улирлаас хамааран жилд 6-7 дугаар сарын турш урт удаан хугацаанд хөлдөнө. Дулааны улиралд бороо чийг ихтэй үед хөрсөн дэх биологийн идэвх ихээхэн дээшилдэг. Давсны өндөр агууламж, органик бодисын бага агууламж, хөрсний шүлтлэг чанар нь хөрсийг салхи, усны элэгдэлд амархан өртөх болон хурдан тархахад хүргэдэг. Энэ нь тухайн нутаг дэвсгэр элэгдэл, эвдрэлд өртөхөд голлох нөлөө үзүүлэх хүчин зүйл болно. Бороо ороход борооны ус 20-25 см гүн хүртэл нэвчих ба нэвчилт ихтэй газрууддаа 25 см-ээс ч илүү гүнд нэвчдэг. Энэхүү борооны дараах газрын гүнд нэвчсэн чийг нь тухайн нутаг дэвсгэрийн ургамлан бүрхэвчийн ургах нөхцөлийг хангахад чухал байдаг.

Нөлөөллийн шинж чанар, эх үүсвэр, хэмжээ, эрчим: Уулын малталт, олборлолтын ажлын талбайг бэлтгэх, зам шинээр гаргах зэрэг хөрсний өнгөн хуулалт хийх, газар шорооны ажлыг эхлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор хөрс эвдэрч элэгдэлд орно. Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсэж хөрс эвдрэх магадлалтай. Олборлолтын үеийн хөрсний эвдрэлээс шалтгаалан шороон шуурга болох нь олшрох, тоосжилт нэмэгдэх, цөлжилтийг эрчимжүүлэх шалтгаан болж болзошгүй.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Уурхайн үйл ажиллагаа тухайлбал тээвэр, нүүрс тээвэр зэргээс болоод уурхай орчмын газар болон машин замын ойролцоо газруудад хөрсний элэгдэл үүсэж, ургамлын нөмрөгийн зүйлийн бүрдэл буурах, амьтад дайжих зэрэг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Мөн хөрсөнд шатах тослох материалын асгаралтаас үүдээд хөрс өөрийгөө цэвэршүүлэх, сэргээх чадвар алдагдах эрсдэлтэй.

Үргэлжлэх хугацаа: Хөрсний элэгдэл эвдрэл нь удаан хугацаагаар үргэлжилнэ. Хөрсний өөрийгөө нөхөн төлжүүлэх чадвар харьцангуй удаан байдаг.

3.3 Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Тухайн бүс нутаг хойд хэсгээрээ Тост (2517м), Хүрэн хана (2397м), Ноёны нам өндөртэй нурууд өргөргийн дагуу зурваслан тогтох бөгөөд уулсын бэлийн дагуу гадаргын харьцангуй өндөр 1600 м хүрнэ. Гадаргын өндөржилт нь урд зүгт аажим налуу үүсгэн, Нарийн сухайтын нүүрсний ордын орчим 1500 м үнэмлэхүй өндөртэй болох ба бага зэргийн талархаг гадаргуу үүсгэн бага зузаантай бэл, хормой хурдсаар хучигдаж олон тооны хуурай сайруудаар хэрчигдэн Нарийн сухайтын тохролоос урагшаа жижиг дов, толгодорхог гадаргатай нийлнэ. Ихэнх сайрууд тухайн уурхайн урд хэсгийн толгодорхог гадаргын ар бэлд тулж садарга үүсгэн сарних ба зарим томоохон сайрууд гадаргын үндсэн хэв шинжид хөндлөн чиглэлд хэрчигдэл үүсгэдэг онцлогтой. Дээр дурдсан гадаргын онцлог шинжүүдээс хамааран бүс нутгийн хэмжээнд газрын доорх усны урсац пролювийн сэвсгэр хурдсаар дамжин Овоотын бүсийн толгодорхог гадаргад тулахаас гадна өргөргийн дагуу орших Нарийн сухайтын тохрол, дээд пермийн Дэлийн шанд формацын нүүрс агуулагч хурдсын гарш хэсгүүдтэй давхцан газрын гадаргууд булаг хэлбэрээр илэрдэг.

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулна.

Нөлөөлөлд өртөх зүйлс, тархалт, хамрах хүрээ: Гүний худаг болон гадаргын усаар ундаалдаг хүн, мал амьтан, ургамал. Химийн хорт бодисууд усан сангийн ёроолд тунах үед эсвэл давхаргад

нэвчих үед чулуулгийн хэсгүүдээр адсорбилогдох, исэлдэн ангижрах, тунадасжих гэх мэт процесс явагддаг тул ус өөрөө бүрэн цэвэршиж чаддаггүй. Гүний усанд химийн хорт бодисууд нэвчимтгий чанартай хөрсөнд 10 км ба түүнээс цааш тархаж болно. **Үргэлжлэх хугацаа:** Хөрсөнд нэвчсэн хорт бодис нь гүний усанд уусаж удаан хугацаагаар хадгалагдана.

3.4 Амьтан, ургамал зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалт болон тэсэлгээ, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлын нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй. Нүүрс тээвэр болон тэсэлгээний үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасаж анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах магадлалтай. Буурсан тохиолдолд идэш тэжээлийн гинжин хэлхээнд өөрчлөлт орох, амьтад идэш тэжээлээ даган нүүдэллэх тухайн нутгаас дайжих, хэрвээ идэш тэжээлээр дамжин хүнд металл болон химийн хорт нэгдлүүд амьтны биед орсон тохиолдолд тэдгээрийн гений санд өөрчлөлт орох гэх мэт эрсдэл гарч болзошгүй юм.

БҮЛЭГ 4 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу 2025 онд төлөвлөгөөт ажлуудыг авч хэрэгжүүлэн нөлөөллийг бага түвшинд байлгах, монгол улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон тусгаж боловсруулсан ба тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхэд оршино.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Байгаль орчны хяналтыг сайжруулах, сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах арга хэмжээг богино хугацаанд зохион байгуулах;
- Байгаль орчны чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, өргөжүүлэх;
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулах
- Мод үржүүлгийн талбайн ашиглалтыг сайжруулах төлөвлөгөөг гаргаж тарьц суулгацыг нөөцийг бүрдүүлэн, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарьж төрийн захиргааны төв байгууллагатай уялдаа холбоотой хамтран ажиллах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах дунд болон урт хугацааны төлөвлөгөө гаргах.

БҮЛЭГ 5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд

Зорилго: Уурхайн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бууруулах, хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, орчны агаар дахь хими физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлж болзошгүй, сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт	Тоос дарах бодисын туршилт судалгаа хийж нэвтрүүлэх	Ажлын тайлан	км	Үйл ажиллагааны зардлаас			Жилдээ	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 4585 :2007
2		Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгааг оновчтой зохион байгуулах	Уурхайн дотоод зам тээврийн талбай	км	Шүүрлийн усны нэгж үнэ			Өдөр бүр	
3		Нүүрс тээврийн ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах	Нүүрс тээврийн зам талбай	Тайлан	Үйл ажиллагааны зардлаас			Сар бүр	
4	Төслийн үйл ажиллагаанаас агаар мандалд ялгарч буй хүлэмжийн хий	Хүлэмжийн хий ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тоолох, мэдээлэх	Уурхайн хэмжээнд	Тайлан	Үйл ажиллагааны зардлаас			Сар бүр	MNS ISO 14064.1.2015

5	Засвар үйлчилгээний төвийн уурын зуухнаас ялгарах хорт утаа	Ашиглагдаж буй уурын зууханд хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ хийлгэх	Уурхайн хэмжээнд	Тайлан	2.000.000	X-IV-р сар	Дотоод дүрэм журам мөрдүүлэх
НИЙТ					2.000.000		

6.2 Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд

Зорилго: Уурхайн ажилчдын амьдрах орчинд ямар нэгэн бохирдолгүй усыг унд ахуйд хэрэглэх, уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 3 Усан орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гадаргын усан орчныг хамгаалах, Гүний усыг хамгаалах	Уурхайн худгийн тоолууруудын заалтыг авч акт үйлдүүлэх	Усны эх үүсвэр	ш	Үйл ажиллагааны зардлаас			Сар бүр	Усны тухай хууль
2		Булгийн ойр орчмыг хашиж хамгаалах, фото мониторингийн судалгаа хийх	Уурхайн эргэн тойрны булаг	ш	2.000.000	1	2.000.000	Жилдээ	Усны тухай хууль
3		Цэвэрлэх байгууламжийн цэвэрлээд гарч буй бохир усанд байнгын хяналт тавих	Уурхайн хэмжээнд	ш	-	4	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	Усны менежментийн төлөвлөгөө
4	Гүний усыг хамгаалах	Дэлхийн усны өдрөөр уурхайн ажилчдын дунд тэмдэглэн өнгөрүүлэх	Уурхайн хэмжээнд	ш	3.000.000	1	3.000.000	1-р улиралд	Усны тухай хууль
5		Усны зүй зохистой хэрэглээ, усны менежментийн талаар нийт ажилчдад сургалт орох	Нийт ажилчдын дунд	ш	-	4	-	Улирал бүр	Усны тухай хууль

6	Ус ашиглах дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх.	Уурхайн хэмжээнд	ш	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	Усны тухай хууль
НИЙТ				5,000,000		

6.3 Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээг бууруулахад оршино.

Хүснэгт 4 Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газрын хэвлий болон үржил шимт өргөн хөрс эвдрэлд орох	Хөрсний овоолго болон ил уурхайн тэлэлт хийхэд тухайн хэсгийн шимт хөршийг стандартын дагуу хуулж авах	Уурхайн хэмжээнд	га	Үйл ажиллагааны зардлаас		Тухай бүрд	Уурхайн байгаль орчныг хамгаалах дотоод журам, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	
2		Засвар үйлчилгээний талбайд хөрс саармагжуулах талбайн хэмжээг томсгох	Бохирдолтой хөрс саармагжуулах талбай	га	Үйл ажиллагааны зардлаас		Ш-р улирал		
3		Хөрс бохирдуулагч нүхэн жорлонг бууруулах ажлыг орон нутагт зохион байгуулах	Гурвантэс сум	ш	5.000.000	3	15.000.000		Ш-р улирал

4		Дэлхийн хөрсний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	Сурагчид болон уурхайн ажилчдад	-	3.000.000	1	3.000.000	IV-р улирал
5	Газрын гадарга, хэвлий өнгөн хөрс бохирдол, доройтолд өртөх	Байгууламжуудтай холбоотой бий болсон газрын эвдрэлийг багасгах, засах, уурхайн үйл ажиллагаанд өртсөн зам талбайнуудад тухай бүрд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	Уурхайн хэмжээнд	га	Үйл ажиллагааны зардлаас		Тухай бүрд	
НИЙТ					18.000.000			

6.4 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Зорилго: Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй бүс нутагт тархсан зэрлэг ан амьтанд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 5 Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		Уурхай орчмын 20км радиуст амьтны судалгаа хийх	Уурхайн орчимд	1 удаа	Үйл ажиллагааны зардлаас			Жилдээ	Амьтны судалгаа хийх аргачлал
2	Уурхайн олборлолт, барилга байгууламж өргөжин тэлж байгаагаас зам,	Уурхайн үйл ажиллагааны талбай дэд бүтэц, цахилгааны шугам дагуух үхсэн амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах, хорогдсон амьтадын бүртгэл хөтлөх	Уурхайн орчимд	Эндсэн амьтдын тоо	Үйл ажиллагааны зардлаас			тогтмол	Амьтны тухай хууль

3	тээврийн хэрэгслийн хөдөлгөөний гэрлийн нөлөөгөөр байршиж буй газраасаа ан амьтанд үргэх дайжих, амьдрах орчны хомсдолд орох	Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авах	Гурвантэс суманд	ш	3.000.000	1	3.000.000	Жилдээ	Амьтны тухай хууль
4		"Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Сурагчид болон ажилчдын дунд	ш	3.000.000	1	3.000.000	3-р улиралд	"Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх
5		Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж анхааруулах тэмдэг байрлуулж, байнгын хараа хяналт тавих.	Уурхайн хэмжээнд	ш	Үйл ажиллагааны зардлаас			Жилдээ	Амьтны тухай хууль
НИЙТ					6.000.000				

6.5 Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Зорилго: Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй бүс нутагт тархсан байгалийн ховор, нэн ховор ургамлын аймагт үзүүлж буй сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх, бууруулахад оршино.

Хүснэгт 6 Ургамлын аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ургамлан нөмрөг, төслийн үйл ажиллагаа явагдах орчинд ургамлан бүрхэвч	Ховор, нэн ховор ургамалд үзүүлж буй болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд ажиглалт судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх	Уурхайн орчимд	Судалгааны тоо				Жилдээ	Судалгаа хийх аргачлал Байгаль хамгаалах тухай хууль

2	сүйтгэгдэж, доройтох.	Тухайн бүс нутгийн онцлогт тохирсон болон зонхилогч олон наст ургамлыг тарих бодлого баримталж ажиллана.	Уурхайн орчимд	Эндсэн амьтдын тоо	Үйл ажиллагааны зардлаас			II улирал, Цөлжилттэй тэмцэх өдөр
3		Газар хөндөх бүсэд өртөж буй ховор ургамлыг хамгаалах, шилжүүлэн суулгах арга хэмжээ зохион байгуулах	Гурвантэс суманд	ш	2.000.000	1	2.000.000	Жилдээ
НИЙТ					2.000.000			

БҮЛЭГ 7 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Хүрэн толгой уурхай нь орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цаашид нөхөн сэргээлт болон шимт хөрсний овоолгын хадгалалтыг сайжруулахад ашиглах говийн унаган болон дасан зохицон ургах чадвартай ургамлуудыг үрээр болон суулгацаар тарьж үржүүлэх, турших тал дээр түлхүү анхааран ажиллаж байна. 2025 онд энэхүү ажлыг илүү боловсронгуй, үр дүнтэй болгох үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Үүнд:

Хүснэгт 7 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		Заг тарих талбайг хашиж хамгаална	га	10	Үйл ажиллагааны зардлаас			
		Заг тарих	ш	10000				
	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Гурвантэс сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	ш	2000	4000	8.000,000	2-3 улиралд	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд
		Бүх нийтээр мод тарих өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, мод тарих	ш	2,500	4000	10,000,00	II-р улиралд	
5		Ажилчдын хотхон орчмын талбайд хөрсийг нөхөн сэргээж	га	0.2				MNS 5916:2008 MNS 5917:2008

	зүлэгжүүлж, цэцгийн мандал, мод, бут тарина.			Үйл ажиллагааны зардлаас
6	Уурхайн талбайд тарьсан мод бут уулын ахилт, тэлэлтэд өртөж болзошгүй мод бутыг шилжүүлэн суулгах.	га	0.2	
7	Хуулсан шимт хөрсийг хадгалах, төслийн үйл ажиллагаа дууссаны дараа хөрсийг бүтцийн дагуу дахин хучиж сэргээнэ. Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хадгалах	га	0.2	
Нийт				18,000,000

БҮЛЭГ 8 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 8.4.6 заалтын дагуу Хүрэн толгой уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад учруулж байгаа байгаль орчны сөрөг нөлөөллийг “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” арга хэмжээний судалгаа олон төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх

Хүснэгт 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	Хөхөлзөхийн говьд тархсан нэн ховор тоорой модны амьдрах орчныг сайжруулах буюу хашиж хамгаалах	Хөхөлзөхийн говь	га	-	-	3.000.000	Жилдээ	"Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээний
2		Талын пост хэмээх газар зэрлэг ан амьтанд зориулсан инженерийн хийц бүхий уст цэг 2021 онд байгуулсан түүний хэвийн ажиллагаа болон зэрлэг амьтад ундаалж байгаа зэрэгт хяналт тавих	Хөхөлзөхийн говь			-	-	1.000.000	



Хүрэн толгой үүрхэйн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Орон нутгийн иргэд болон орон нутгийн захиргаанаас санал болгосон тус бүс нутагт хамгаалах шаардлагатай байгаа булгийн эхийг сэргээх	Хөхөлзөхийн говь	ш	-	1	5.000.000	Жилдээ	дүрэм журмыг дагаж мөрдөн ажиллана.
НИЙТ					9.000.000			

БҮЛЭГ 9 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨӨГӨӨ

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь МУ-005459 Тусгай зөвшөөрлийн 70.47 га уурхайн эдэлбэр газар болон бусад хэлбэрийн газрыг зохих зөвшөөрлийн дагуу ашиглаж байна. Компан нь 2003 оны 03-р сараас үйл ажиллагаа явуулж ашигт малтмалын орд ашиглах 5459А дугаарын лиценз эзэмших талбайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 4-р багийн малчин Лувсан овогтой Баярсайханы эзэмшил болох Нарийн сухайтын Шандын өвөлжөө, Хөх толгой, Хөөврийн хаваржаа орсон байна. Иймд манай компани нь МУ-ын газрын тухай хуулийн 56-р зүйлийн 2,3 иргэний хуулийн 110, 113-р зүйл Гурвантэс сумын ЗДТГ-тай харилцан тохиролцож хүлээсэн үүргийн дагуу малчин Л.Баярсайханы өвөлжөө бууцыг нүүлгэн шилжүүлж шинээр сэргээн барьж байгуулсан. 2026 онд ажил төлөвлөгдөөгүй.

БҮЛЭГ 10 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь 2005 онд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Тогтвортой байдлын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт БНХАУ-ын Сэхээ-Монгол улсын Шивээхүрэнгийн боомт-Нарийн сухайтын уурхай хүртэл 56 км хатуу хучилттай зам барих тусгай зөвшөөрлийг Зам тээвэр, Аялал жуулчлалын Яамнаас авч, замын барилга байгууламжийн ажлыг эхэлжээ.

Тус хүрээлэнгийн судалгааны баг Монгол улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн 6-р бүлгийн 17-гийн 10-т заасны дагуу нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд хатуу хучилттай авто зам барих газарт 2007 оны 10-р сарын 23-наас 31ны хүртэл 7 хоногийн хугацаатай археологийн урьдчилсан хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ судалгааны ажлын хүрээнд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс тохиолдоогүй болно.

Ийм учраас Хүрэн толгой уурхай нь Соёлын биет бус өвийг хамгаалах арга хэмжээг төлөвлөн ажиллах болно.

“Соёлын биет бус өв” гэдэг нь тухайн ард түмэн, үндэстний оюун санаагаар бүтэж, уламжлагдан ирсэн түүхэн тодорхой орон зайг төлөөлж чадах эх хэл, ардын мэдлэг, амьдрах арга ухаан, байгаль ертөнцийн тухай мэдлэг, хөдөлмөрийн зан үйл, наадам наргиа, ёс заншил, дуу хөгжим, уламжлалт гар урлал, түүний ур хийц, технологи зэрэг соёлын орон зайг хэлнэ.

Монгол улс Соёлын биет бус өвийг анхлан Утга соёлын өв, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг Өвлөн тээгч хэмээн нэрлэж байсан ба 2010 онд Монгол улсын Төрийн хэлний зөвлөлөөс Соёлын биет бус өв, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж нэрлэх нь зүйтэй гэсэн чиглэлийн дагуу одоогийн нэршлийг хэрэглэж байна.

“Хүрэн толгой коал майнинг” ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумд 2005 оноос жил болгон ивээн тэтгэж уламжлал болгон цагаан сарын өмнө “Тэмээн сүргийн баяр”-ыг зохион байгуулдаг билээ. Энэ удаагийн “Тэмээн сүргийн баяр”-ын арга хэмжээг 2026 оны 1-р улиралд зохион байгуулна.

БҮЛЭГ 11 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх	Уурхайн хэмжээнд		Үйл ажиллагааны зардлаас		3-4-р улиралд	Гамшгаас хамгаалах тухай хууль
2	Уурхайн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг тогтвортой байдлыг хангаж ажиллах	Уурхайн хэмжээнд		Үйл ажиллагааны зардлаас		Тухай бүрт	MNS BS 8525-1:2015
3	Хаягдал тосны ёмкос дүүрэхэд гэрээт компаниуд хүлээлгэн өгөх	Уурхайн хэмжээнд		10.000.000		Тухай бүрт	ОБ Ойл ХХК болон Саус Ресурс ХХК хамтран ажиллах гэрээ
Нийт зардал						10,000,000	

БҮЛЭГ 12 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

12.1 Хог хаягдал

Төслөөс гарах хатуу хог хаягдлын хувьд ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай хаягдал гарах бөгөөд ахуйн гаралтайд 196 орчим ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог, цаас гэх зэрэг хуурай хаягдлууд хамаарна. Үйлдвэрийн гаралтай хатуу хог хаягдлын хувьд гадаад дотоод овоолгод байршуулагдах хөрсний чулуулаг, хөрс хуулалтын ажлын явцад хуулагдах балансын нөөцийн зарим хэсэг, ус цэвэрлэх цөөрөм, байгууламжийн тундас зэргээс мөн хаягдал шуудай, машин техник, тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийн хаягдал болон төмөр утас зэрэг хаягдлууд хамаарна. Үүнээс метал болон бусад дахин ашиглах боломжтой хог хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэн борлуулах арга хэмжээ авах нь зүйтэй. Уурхайн хатуу хог хаягдлаас төмөр, хөнгөн цагаан, хүхэр, натри, магни, кали, кальци, цахиур, титан болон бичил элементүүд орчныг бохирдуулж болзошгүй. Гиймээс уурхайн олборлолтын явцад уурхайн үйл ажиллагаа болон ажилчдын ахуйн хэрэглээний хатуу хог хаягдлыг дахин боловсруулж болох, эс болох төрлөөр нь ангилан дахин боловсруулж болох хаягдлыг түүхий эд авах цэгт тушааж, дахин боловсруулахгүй хогийг сумын нэгдсэн хогийн цэгт нутгийн захиргаатай гэрээ байгуулан хаях шаардлагатай. Мөн хатуу хог хаягдал түр хаях цэгийн талбайн суурийг бетондон бохирдлыг хөрсөнд нэвчихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.

Шингэн хаягдал

Уурхайн шингэн хаягдалд уурхайн хаягдал ус болон уурхайн ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдал багтах бөгөөд эдгээрээс тундас бодис, нефтийн бүтээгдэхүүнүүд, фенол, сульфат, хлорид, карбонат, гидрокарбонат, азотын нэгдлүүд, хүнд болон хөнгөн металлуудын ионууд, бактери зэрэг бохирдуулагч элементүүд үүснэ.

12.2 Хийн хаягдал

Машин механизмын хөдөлгүүрээс утаа, угаар, хөө, тортог, хорт бодис ихээр агаарт хаягддаг. Энэ нь агаар орчныг бохирдуулах, ажиллагсдын эрүүл мэнд болон ойр орчмын хөрс, ургамлын бүрхэвчид муугаар нөлөөлж болзошгүй байна. Хийн хаягдлуудаас шалтгаалан тоос, тортог, азот, нүүрстөрөгчийн ислүүд, хүхрийн давхар исэл, хүхэрлэг устөрөгч, аммиак, формальдегид, фосфорын ангидрид, хлор, бензапирен болон бусад бичил элементүүд ялгаран агаар орчныг бохирдуулж болзошгүй. Уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг анхан шатанд нь ангилан ялгалт хийж хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглагдах хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хадгалах, ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд уурхайн хэмжээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

- Төв оффис, Уурхайн орчны цэвэрлэгээ
- Хатуу хог хаягдлын хадгалалт, хяналт
- Ахуйн хог хаягдлын ангилан ялгалт
- Хатуу хучилтын 56 км авто замын хажууг цэвэрлэх
- ШТС-ын ойр орчим

Уурхайн болон ахуйн хэрэглээнээс үүсэж бий болсон хогыг ангилан ялгаж хогийн төвлөрүүлсэн цэгт булж дардаг. Мөн орчны цэвэрлэгээг тогтмол хийдэг бөгөөд уурхайн тосгон, ажилчдын тосгон, уурхай хүртэлх замын дагуух хогийг цэвэрлэдэг.

12.3 Химийн бодисын эрсдэлийн менежмент

Аюултай химийн бодис уурхайд ашигладаггүй. “Бласт” ХХК–иар тэсэлгээний ажлыг гэрээгээр хийлгэх бөгөөд үүссэн хог бохирдлыг бүрэн хариуцаж технологийн дагуу өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийдэг. Уурхайн ашиглалтын явцад уурхайн хүнд машин механизмын эд анги, ашиглагдсан тос, тослох материал, аккумулятор, дугуй гэх мэт сэлбэг хэрэгсэл, дахин ашиглагдах хоёрдогч түүхий эдийг тодорхой цэгт төвлөрүүлэн хуримтлуулан хадгалж аж ахуйн нэгжүүдэд нийлүүлдэг.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дахин боловсруулах, ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг гэрээт компаниар устгуулах	Гэрээний дагуу	м3	55,000	-	-	Тухай бүрт	"Шугшаа Уул" ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээ
2		Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардлаас		Сар бүр	Хог хаягдлын тухай хууль	
3	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг нэр төрөл бүрээр бүртгэн, бүртгэл хөглөх	Гэрээний дагуу	-	-	-	-	Сар бүр	2025 БОМТ дүгнэлт
4		Аюултай хог хаягдлын үүсгэгчийн тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх	Хуулийн дагуу	-	-	-	-	Тухай бүрт	
5		Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах устгах	Уурхайн орчимд	ш	Үйл ажиллагааны зардлаас		Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль	

	журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх						
6	Аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн эх үүсвэр дээрээс нь нийлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Гэрээний дагуу	төг	-	-	20.000.000	Тухай бүрт
Нийт				20.000.000			

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Хүснэгт 9 Хог хаягдлаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

БҮЛЭГ 13 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

13.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Хүрэн толгой нүүрсний уурхайг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүнийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулсан болно.

Орчны хяналт шинжилгээний нэгдсэн хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэг чухал хэсэг байдаг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсдын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг хянах орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх удирдамж болдог.

Тус төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөх зорилготой.

Байгаль орчны 7 бүрэлдэхүүн хэсэгт хийгдэх нийт 9 төрлийн хяналт шинжилгээ явуулах хэлбэрийг боловсруулан оруулав. Зардлын тооцоонд зөвхөн дээж сорьцыг авах болон түүнийг шинжлүүлэх лабораторийн шинжилгээний зардлыг тооцсон.

Орчны хяналт шинжилгээний ажлыг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. Мөн байгууллагын дотоодын хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг тухай бүр хянах, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан ажилтан сар болон улирал тутам хяналт шинжилгээний дүн мэдээгээр тайлан бэлтгэж, зохих удирдлагадаа тайлагнаж байна.

Хүрэн толгойн уурхайн онцлог нь энэ бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй сөрөг нөлөөлөл хуримтлагдах, хамсах нөхцөлтэй бөгөөд ялангуяа энэ нь агаар орчинд үзүүлж буй нөлөөлөл дээр тод илэрнэ. Иймээс уг бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй төсөл хэрэгжүүлэгчид байгаль хамгаалах үйл ажиллагаагаа хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй байх болно.

Орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтан хээрийн хэмжилт, дээжлэлтийг хийх ба үр дүнг тайлагнахдаа Монгол улсын холбогдох стандартад харьцуулан үзэх, мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран ажиллаж зөвлөгөө авах, итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллах, эрх бүхий субъектээр дүгнэлт гаргуулах хэлбэрээр ажиллана.

Агаар орчин

№	Орчны хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Агаарын найрлага дахь тоосонцор, чийгшэл, салхины хурд, температур
1	Хяналт шинжилгээний төрөл ба хэлбэр	Мониторинг хийх
2	Хяналт шинжилгээ хийх газрын байршил	Уурхайн бүс болон харьцуулах цэг дээр мөн уурхайн бүсийн зонхилох салхины дээд болон доод талд, Нүүрс тээврийн зам дагуу
3	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Жил бүр
4	Хяналт шинжилгээний арга зүй, аргачлал	Газар дээр нь агаарын шинжилгээ хийнэ
5	Хяналт шинжилгээ явуулах тоног төхөөрөмж	Агаарын тоос, чийгшил хэмжих багаж
6	Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл тайлангийн хүснэгт	Хяналт шинжилгээний бүртгэл тайлан хийх батлагдсан маягтын дагуу
7	Хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулах ба боловсруулах	Хяналт шинжилгээний болон ашиглалтын үр дүнг жил бүрийн 11/01-ний дотор БОАЖГ-рт тайлагнах
8	Хяналт шинжилгээний жиших үзэх MNS, стандарт	Монгол улсын стандарт агаар орчны чанарын үзүүлэлт

Гадаргын болон газар

№	Орчны хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Усны ерөнхий хими ба хүнд металлын шинжилгээ болон шүүрүүлсэн усны хэмжээ түвшин, ундарга тодорхойлох
1	Хяналт шинжилгээний төрөл ба хэлбэр	Дээж авч шинжилгээ хийх, мониторинг хийх
2	Хяналт шинжилгээ хийх газрын байршил	Карьерын ус, тунгаагуурын ус, хөрсөнд хаяж буй ус, ойролцоох малчдын худгууд, хяналтын цооногууд
3	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Улирал бүр
4	Хяналт шинжилгээний арга зүй, аргачлал	Дээж авч хээрийн болон лабораторийн шинжилгээ хийлгэх
5	Хяналт шинжилгээ явуулах тоног төхөөрөмж	Мэргэжлийн байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж, MDS метр, рН метр, дээж хийх сав
6	Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт	Эрх бүхий байгууллагын гаргасан маягт
7	Хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулах ба боловсруулах	Хяналт шинжилгээний болон ашиглалтын үр дүнг жил бүрийн 11/15-ны дотор БОНХЯ-нд тайлагнах
8	Хяналт шинжилгээ хийх байгууллага	Геологийн төв лаборатори, ШУА Геозкологийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
9	Хяналт шинжилгээний жишиж үзэх MNS, стандарт	Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS: 900-2005

Хөрс

№	Орчны хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Хөрсний ялзмаг техник бүрэлдэхүүн, давсны агууламж, хөдөлгөөнт элемент, бактериологийн үзүүлэлт, хүнд металлын агууламж тодорхойлох
1	Хяналт шинжилгээний төрөл ба хэлбэр	Ашиглалтын хугацаанд хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг сорьц авч шинжлүүлэх
2	Хяналт шинжилгээ хийх газрын байршил	Уурхайн бүс, уурхайн засварын төв, шатахууны агуулах, нөлөөлөлд өртөөгүй болон нөхөн сэргээлт хийгдсэн талбай, шимт хөрсний овоолго, нүүрсний тээврийн зам дагуу
3	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хагас жил тутамд
4	Хяналт шинжилгээний арга зүй, аргачлал	Дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэх
5	Хяналт шинжилгээ явуулах тоног төхөөрөмж	Мэргэжлийн байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж
6	Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт	Эрх бүхий байгууллагаас гаргасан маягт
7	Хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулах ба боловсруулах	Хяналт шинжилгээний болон ашиглалтын үр дүнг жил бүрийн 11/15-ны дотор БОНХЯ-нд тайлагнах
8	Хяналт шинжилгээ хийх байгууллага	Байгаль орчны төв лаборатори, ШУА Газарзүйн хүрээлэнтэй хамтарч ажиллах ТTRC-тай хамтран ажиллах
9	Хяналт шинжилгээний жишиж үзэх MNS стандарт	Эрүүл хөрсний суурь үзүүлэлттэй

Ундны ба ахуйн ус

№	Орчны хяналт шинжилгээ явуулах үзүүлэлтүүд	Маркшейдерын судалгаа хийж, газрын хотойлт болон суултыг тодорхойлох
1	Хяналт шинжилгээний төрөл ба хэлбэр	Ажилчдын хотхон
2	Хяналт шинжилгээ хийх газрын байршил	Ундны усны цорго, цэвэрлэх байгууламжид нийлүүлж буй болон гарч буй ус
3	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Улирал бүр
4	Хяналт шинжилгээний арга зүй, аргачлал	Дээж аван шинжилгээ хийх
5	Хяналт шинжилгээ явуулах тоног төхөөрөмж	Мэргэжлийн байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж
6	Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл тайлангийн хүснэгт	Эрх бүхий байгууллагаас гаргасан маягт
7	Хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулах ба боловсруулах	Хяналт шинжилгээний болон ашиглалтын үр дүнг жил бүрийн 11/15-ны дотор ААНХВ – іа хүргүүлэх тайланд хавсаргах
8	Хяналт шинжилгээ хийх байгууллага	УСУГ-н Усны лаборатори, Өмнөговь аймгийн стандарт хэмжилзүйн лаборатори, ТTRC-тай хамтарч ажиллах

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1. Агаарын хяналт шинжилгээ							
1	Тоосжилтын хэмжээ (PM2.5 PM 10)	Уурхайн хяналтын цэгүүдэд	Улирал бүр	4	200.000	800,000	“Агаарын чанар”, MNS 4585:2016 “Агаар орчны чанарын үзүүлэлт”
2	Агаар бохирдуулах эх үүсвэрийг хянах (NO ₂ , SO ₂ , CO, CO ₂)						
2. Усны хяналт шинжилгээ							
3	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж, Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	Уурхайн худаг бүрээс /нийт-3 худаг/ Уурхайн шүүрлийн уснаас /1 цэгээс	Улирал бүр	4	200.000	800.000	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
4	Ахуйн хаягдал усны хяналт шинжилгээ	Ахуйн хаягдал ус цэвэрлэх байгууламж	Улирал бүр	1	200.000	200.000	
3. Хөрсний хяналт шинжилгээ							
5	Ялзмагийн агууламж, рН, давсжилт, чийгшил, NO ₃ -N, P ₂ O ₅ , K ₂ O, рН, нийт азот, нийт фосфор,	Нөлөөлөлд өртөөгүй талбай Шимт хөрсний овоолго	Улирал бүр	4	250.000	1.000.000	MNS 5850:2008
6	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрс ус төрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	Хогийн цэг Цэвэрлэх байгууламж Засвар үйлчилгээний төв Шимт хөрсний овоолго ШТС	Улирал бүр	4	200.000	800.000	
4. Ургамлын хяналт шинжилгээ							

7	Ургамлын гарц, ургац, төрөл зүйл, бүлгэмдэл, ховор ургамал зэргийг судлан мониторинг хийх	Ургамлын хяналтын цэгүүдэд	7-р сард	1		300.000	250.000	Зүйлийг тоолж бүртгэх бүрхэц арвийг нүдэн баримжааны аргаар
8	Үрийн соёололт хяналт мониторинг хийх /заг, хайлаас, гүйлс/	Уурхайн орчимд	5,9-р сард	1		300.000	250.000	Үр түүх стандарт
5.Амьтны хяналт шинжилгээ								
9	Амьтан /анхан шатны мэдээлэл цуглуулах/ амьтны төрөл зүйл бүртгэж авна.	Амьтны хяналтын цэгүүдэд	Улирал бүр	4		200,000	800,000	“Монгол орны хөхтөн амьтдын экологи биологийн нэгдсэн аргазүй”, “Барих-Тэмдэглэх Дахин тэмдэглэх аргазүй”,
Нийт							5.000.000	

БҮЛЭГ 14 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг мэргэжлийн ажилтан, багт хариуцуулах
- Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтан нь уурхайн дээд шатны удирдлагад шууд харьяалагдаж ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг төлөвлөж ажиллах
- Олборлолт явуулсан талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай зэрэгцүүлэн хийх
- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэж өгөх
- Уурхайн бүх ажлыг ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулах, технологийн процессыг паспортжуулах
- Олборлолтын явцад археологи, палентологи, түүх, соёлын дурсгалт зүйлс илэрвэл сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж хамгаалах арга хэмжээ авах
- Орон нутгийн засаг захиргаа олон нийтийн байгууллага иргэдийн санал бодлыг сонсож зохих арга хэмжээ авах харилцан мэдээлэл солилцож байхаас гадна ажилчдын эрүүл мэнд байгаль орчныг хамгаалах, гэнэтийн болзошгүй осол аюулыг арилгах чиглэлээр аймгийн мэргэжлийн хяналтын газар болон сумын ЗДТГазартай нягт хамтарч ажиллах
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл газар хөдлөлт үер салхи шуурга болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг нэгээс хоёр удаа сургаж дадлагажуулах энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллах
- Уурхайн ажиллагсдын дунд байгаль хамгаалах талаар ухуулга яриа сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж байнга бэлэн байлгах
- Уурхайн ухаш усан сан болон суваг шуудуу нь хүн мал амьтан унах живж осолдохоос сэргийлсэн хаалт хашлагатай байх бөгөөд эргэн тойронд нь анхааруулах хориглох санамж тавьж ослоос сэргийлэх арга хэмжээ авах
- Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч ус хөрс агаарын бохирдол хөрсний эвдрэл элэгдэл усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах
- Шатахуун хадгалах түгээх станцын галын аюулгүй ажиллагааг найдвартай хангаж тус шатахуун алдах хаях уурших явдлыг гаргахгүй байхыг онцгой анхаарах гэх мэт

Зорилго: Уурхайн үйл ажиллагаа явуулах хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгаа, мөрдөгдөх журам, төлөвлөгөөг цаг алдалгүй хийх тухайн ажлыг зөв зүйтэй зохион байгуулахад оршино.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Даланзадгад-Гурвантэс сум 15км замын арчилгааг хийж, тайлагнах	Дотоод	4	3.000.000	Улирал бүр	Хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
2	2026 онд зохион байгуулагдах байгаль орчны чиглэлийн семинар, хурал зөвлөгөөнд оролцох	Орон нутаг	-	3.000.000	-	Дотоод батлагдсан төлөвлөгөөний хүрээнд
3	Хүрэнтолгой-Бага-Овоо багийн хүртлэх 3,7 км замын арчилгааг тогтмол хийж, тайлагнах	Дотоод	12	3.000.000	Сар бүр	Хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
Нийт				9.000.000		

БҮЛЭГ 15 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино. Дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв. Үүнд:

- Орон нутгийн иргэдтэй уулзаж хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээллийг хүргэж байх
- Төрийн байгууллагуудад журмын дагуу тайлангийн биелэлт, гүйцэтгэлийг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх (Тухайн цаг хугацаанд)
- Бусад үед шаардлагатай мэдээ, судалгааг гаргаж төрийн байгууллагуудад хүргүүлэх (Тухайн цаг хугацаанд)

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах	Бага-Овоо багийн иргэд	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	Улирал бүр	3,000,000	Байгаль орчны мэргэжилтэн	Бага-Овоо багийн төв, уурхайн сургалтын танхим
2	“Нээлттэй өдөрлөг”-т оролцож, 2026 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга хийнэ	Тайлан		Зарлагдсан хугацаанд	3,000,000		Өмнөговь аймгийн Даланзадгад
Нийт					6,000,000		

БҮЛЭГ 16 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО

№	Төсөв зохион байгуулалт	Дүн /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	33.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	9.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Үйл ажиллагааны зардлаас
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	10.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	5.0
9	Байгаль орчин удирдлага зохион байгуулалт	9.0
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	6.0
	Дүн	110.0



Хүрэн толгой уурхайн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө